



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ХӨДӨЛМӨРИЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

20 16 оны 03 сарын 24 өдөр

Дугаар A/11

Алтай хот

Төсөл сонгон шалгаруулах
комисс томилох тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3, 6.3.6, 6.3.7, 12 дугаар зүйлийн 12.2, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2015 оны 02 сарын 12-ны өдрийн 7 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт, Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөрийн 3 дугаар зүйлийн 3.3.1, 3.3.2, 3.3.5, 3.3.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Хувиараа хөдөлмөр эрхлэгч нөхөрлөл хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж байгаа санхүүгийн дэмжлэг олгох төслүүдийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж байгаа төслүүдийг сонгон шалгаруулах комиссыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Ажлын хэсэг нь ашиг сонирхолын зөрчилгүй эсэхээ илэрхийлсэн мэдэгдлийг хууль журмын дагуу үнэн зөв гаргаж, хариуцлагатай ажиллахыг бүх гишүүдэд үүрэг болгосугай.

3. Сонгон шалгаруулалтанд тэнцсэн, цаашид хэрэгжих боломжтой төслүүдтэй нэг бүрчлэн ажлын байранд нь танилцаж, 2016 оны 03 сарын 28-ны дотор Хэлтсийн даргад танилцуулахыг комиссын ахлагч нарт даалгасугай.


4. Төслүүдийн сонгон шалгаруулалтын үйл явц болон, шалгарсан төслүүдэд хяналт үнэлгээ хийж, дүнг 2016 оны 04 сарын 01-ний дотор таилагнахыг дотоод хяналт үнэлгээ, үйл ажиллагааны тайлан хариуцсан мэргэжилтэн Б.Баярмаад үүрэг болгосугай.

ДАРГА



М.МЯНГАНБУУ


Хөдөлмөрийн хэлтсийн даргын
2016 оны 03 дугаар сарын 24-ны
өдрийн 4/1 дугаар тушаалын
2 дугаар хавсралт



Сонгон шалгаруулах комисс

№	Овог нэр	Албан тушаал	
1	Т.Эрдэнэсүрэн	Төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн	Комиссын ахлагч
2	Х.Мөнгөнхорол	Дотоод хяналт шалгалт үйл ажиллагааны тайлан хариуцсан мэргэжилтэн	Гишүүн
3	Д.Дашдорж	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоодын удирдах зөвлөлийн гишүүн	Гишүүн

Хөдөлмөрийн хэлтсийн даргын
2016 оны 03 дугаар сарын 24 -ны
өдрийн 1/1 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт



Сонгон шалгаруулах комисс

№	Овог нэр	Албан тушаал	
1	Х.Энхтайван	Төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн	Комиссын ахлагч
2	Н.Гантуяа	Ажилд үйлчилгээ, мэдээлэл мэргэжилтэн	зуучлах зөвлөгөө хариуцсан Гишүүн
3	Б.Алтайбаатар	ХАБЭА-мэргэжилтэн	хариуцсан Гишүүн